

**МЦХ ХК-ИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН ТОГТООЛ**

2015 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

№ 1

Улаанбаатар хот

**Санал хураалтын
дүнгийн тухай**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 3975 хувьцаа эзэмшигчдээс 24 494 502 хувьцаа эзэмшиж буй 14 хувьцаа эзэмшигч саналаа өгсөн байна. Үүнээс 9 саналын хуудас хүчинтэй, 5 саналын хуудас хүчингүй байна.

Саналын хуудсанд нийт 5 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр доорхи санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын 1 дүгээр асуудлыг:

Зөвшөөрсөн	24,494,502	буюу 100	хувь
Татгалзсан		буюу	хувь
Түдгэлзсэн		буюу	хувь

2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2 дугаар асуудлыг:

Зөвшөөрсөн	24,494,502	буюу 100	хувь
Татгалзсан		буюу	хувь
Түдгэлзсэн		буюу	хувь

3. Компанийн Аудитын хорооны тайлангийн талаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын 3 дугаар асуудлыг

Зөвшөөрсөн	24,494,502	буюу 100	хувь
Татгалзсан		буюу	хувь
Түдгэлзсэн		буюу	хувь

4. Компанийн шинэ Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Ердийн гишүүдэд:

1. Ж.Ганбат - 24.493.167 хувьцааны тоогоор буюу 24.999 хувь
2. Ж.Үнэнбат - 24.493.935 хувьцааны тоогоор буюу 24.999 хувь
3. Мүүн Жүнг Ёонг - 24.492.129 хувьцааны тоогоор буюу 24.998 хувь

Хараат бүс гишүүнд:


4. Ёунг Мин Канг - 24.492.567 хувьцааны тоогоор буюу 24.998 хувь
5. ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг батлах талаар Хувь эзэмшигчдийн хурлын 5 дугаар асуудлыг:

Зөвшөөрсөн	24,494,502	буюу 100	хувь
Татгалзсан		буюу	хувь
Түдгэлзсэн		буюу	хувь

МЦХ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 1 дүгээр асуудлыг 100 /хувь/-ийн саналаар, 2 дугаар асуудлыг 100 /хувь/-ийн саналаар, 3 дугаар асуудлыг 100 /хувь/-ийн саналаар, 5 дугаар асуудлыг 100 /хувь/-ийн саналаар батлах нь зүйтэй гэж үзсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИСС ДАРГА



А.ЦЭНДСҮРЭН

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан,
түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо Хувьцаат Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА: TELECOM MONGOLIA Т.БАТМАГНАЙ



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус
аудитын дүгнэлтийг дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх, 96 дугаар зүйлийн 96.5 дах заалт, Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монголын цахилгаан холбоо Хувьцаат Компанийн 2014 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай:

- Нийт хөрөнгийг 40,583,242,013 (дөчин тэрбум таван зуун наян гурван сая хоёр зуун дөчин хоёр мянга арван гурав) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 19,830,473,248 (арван есөн тэрбум найман зуун гучин сая дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуун дөчин найм) төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 20,752,768,764 (хорин тэрбум долоон зуун тавин хоёр сая долоон зуун жаран найман мянга долоон зуун жаран дөрөв) төгрөгөөр
- Өр төлбөрийн нийт дүнг 8,249,064,791 (найман тэрбум хоёр зуун дөчин есөн сая жаран дөрвөн мянга долоон зуун ерэн нэг) төгрөгөөр
- Эзэмшигчийн өмчийг 32,334,177,221 (гучин хоёр тэрбум гурван зуун гучин дөрвөн сая нэг зуун далан долоон мянга хоёр зуун хорин нэг) төгрөгөөр тус тус баталсугай.

2. Компанийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА:



Т.БАТМАГНАЙ

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
Аудитын хорооны тайланг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны тайлан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА: Т.БАТМАГНАЙ



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх, 81 дүгээр зүйлийн 81.5.3 дахь заалт, Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олонхийн санал авсан:

-Ердийн гишүүдэд :

- Жигжид овогтой Үнэнбат
- Жигжид овогтой Ганбат
- Мүүн Жүнг Ёонг

- Хараат бус гишүүдэд :

- Ёүнг Мин Канг

нарыг Төлөөлөн Удирдан Зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Дангаа овогтой Батбаяр, Буянхүү овогтой Алтангэрэл, хараат бус гишүүн Пүрэвээ овогтой Энхбаяр нарыг үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Компанийн үр ашигтай ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: Т.БАТМАГНАЙ



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны
зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх, Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын төсвийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалин хөлсийг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Мүүн Жүнг Ёонг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: Т.БАТМАГНАЙ



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тоот тогтоолын хүтэглэл



МЦХ ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны зардлын төсөв

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт Дүн (мянган ₮)
---	---------------	-----	-------------	---------	---------------------

1. Цалин, холбооны зардал

1	ТУЗ-ийн гишүүдийн цалин	9.0	350.0	12.0	37,800.0
2	ТУЗ-ын н/б дарга, орчуулга	1.0	280.0	12.0	3,360.0
3	ТУЗ-ын н/б дарга холбоо, тээврийн зардал	1.0	150.0	12.0	1,800.0
4	Цалин холбооны зардлын дүн				42,960.0

2. Урамшуулал

1	ТУЗ-ийн хурлын 80 хувьд оролцсон ТУЗ-ийн Дарга, гишүүд	9.0	300.0	1.0	2,700.0
2	ТУЗ-ийн хурлын 80 хувьд оролцсон ТУЗ-ийн дэргэдэх хорооны Дарга, гишүүд	9.0	200.0	1.0	600.0
	Урамшуулалын дүн				3,300.0

3. Бичиг хэрэг ба ёслол

1	Бичиг хэргийн материал		70.5	12.0	846.0
2	Байрны түрээс		235.0	12.0	2,820.0
3	Ёслол ба бусад		117.5	12.0	1,410.0
	Бичиг хэрэг ба ёслолын зардлын дүн				5,076.0

4. ТУЗ-ын хурлыг Монголд буюу БНСУ-д зохион байгуулах

1	Тээврийн зардал	7.0	987.0	1.0	6,909.0
2	Байрны хөлс / 5 өдөр /	7.0	141.0	5.0	4,935.0
3	Визийн хураамж	7.0	50.0	1.0	350.0
4	Томилолт / 5 өдөр /	7.0	70.5	5.0	2,467.5
	ТУЗ-ын хурлыг БНСУ-д зохион байгуулах зардлын дүн				14,661.5м